GCRP ТӨСЛИЙН ТАЙЛАН

2026 • 09-30

Гэр Хорооллын Үерийг Тэсвэрлэх, Чадавхыг Бэхжүүлэх төсөл

Үргэлжлэх хугацаа 2023–2027



ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ: 2 БАЙРШИЛ · ӨМНӨ БА ОДОО · АМЖИЛТЫН ТҮҮХ

21,528

оршин суугч үерээс хамгаалагдав

220.5 га

суурьшлын бүс хамгаалалтад

ADAPTATION FUND

UN HABITAT FOR A BETTER URBAN FUTURE

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ

АГУУЛГА

03 Яагаад энэ төсөл хэрэгтэй вэ?

04 Зорилго ба дөрвөн бүрэлдэхүүн

05 Нэг харцаар: гол үр дүн

06 Бодлого, төлөвлөлт

07 Иргэдийн чадавх, оролцоо

08 Байршил 1: Толгойт гол

09 Өмнө ба одоо: Толгойт

10 Өмнө ба одоо: Толгойт (2)

11 Байршил 2: Гүнжийн булаг, Бэлх

12 Өмнө ба одоо: Гүнжийн булаг

13 Өмнө ба одоо: Бэлх гол

14 Гүүр, гаргуур: аюулгүй зорчих орчин

15 Ногоон шийдэл, иргэдийн оролцоо

16 Уерт тэсвэртэй ариун цэвэр

17 Мэдлэг, түгээлт

18 Амжилтын түүх

19 Сургамж, тогтвортой байдал

УДИРТГАЛ

Уерийн эрсдэлээс тэсвэртэй ирээдүй рүү

Улаанбаатарын гэр хорооллын олон айлын хувьд үер бол жил бүр давтагддаг бэрхшээл. Өвлийн халиа дошин гудамж, хашааг мөсөөр хучиж, хаврын шар ус, зуны аадар бороо айлуудын хашаагаар урсдаг байлаа.

Энэхүү танилцуулганд GCRP төслийн зорилго, дөрвөн бүрэлдэхүүн хэсэг, хоёр байршилд баригдсан үерийн хамгаалалтын байгууламж, иргэдийн оролцоо, сургамжийг **2026 оны 9-р сарын 30-ны** байдлаар нэгтгэн хүргэж байна.

САНХҮҮЖҮҮЛЭГЧ	Дасан зохицох сан (Adaptation Fund)
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын хөтөлбөр (НҮБ-Хабитат)
ХАМТРАН ГҮЙЦЭТГЭГЧ	Хөгжлийн Шийдэл ТББ (2025.07.01-ээс)
ХАМТРАГЧИД	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам; Нийслэлийн Засаг даргын Тамгын газар; СХД, СБД-ийн ЗДТГ, хороод
ТАЛБАР	СХД-ийн 4, 5, 26, 27; СБД-ийн 15, 16, 18, 20-р хороо
ХУГАЦАА	2023–2027 (2027.07.26 хүртэл)
САНХҮҮЖИЛТ	7.9 сая ам.доллар



ҮНДЭСЛЭЛ

Яагаад энэ төсөл хэрэгтэй вэ?



Уур амьсгалын өөрчлөлт, төлөвлөлтгүй тэлэлт хоёр давхцахад гэр хороолол үерийн эрсдэлийн голомт болж байна. Айлууд уулын энгэр, голын сав руу тэлж, дэд бүтэц хоцорсон.

24.9 км²
талбай үерт автах эрсдэлтэй

52,839
хүн эрсдэлтэй, үүнээс 12,564 нь маш өндөр

+2.6°C
УБ-ын дундаж дулаарал 75 жилд

2 дахин
хотын хүн ам 2000–2025 онд 773 мянгаас 1.5 сая

Жилийн турш гурван төрлийн үер

ӨВӨЛ

Халиа дошин

Цэвдэг гэсэж, газар доорх булаг оргилон гарч, гудамж, хашааг мөсөөр хучдаг.

ХАВАР

Шар усны үер

Уулын цас хайлж, их хэмжээний ус гэр хороолол руу урсаж ордог.

ЗУН

Аадар бороony үер

Богино хугацааны хүчтэй бороо уулын ам, жалгаар огцом үер үүсгэдэг.

Гол асуудлууд

Дасан зохицох бодлого хот, орон нутгийн төлөвлөлтөд тусаагүй; дэд бүтэц, ариун цэврийн байгууламж хүртээмжгүй; санхүүжилт дутмаг; иргэдийн мэдлэг, чадавх сул байлаа. 2050 он гэхэд хотын нутгийн **20.8%** нь үерт өртөмтгий болох төлөвтэй.

ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Нэг зорилго, дөрвөн бүрэлдэхүүн

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Гол, уруйн үер, халиа дошинд автах өндөр эрсдэлтэй Улаанбаатар хотын гэр хорооллын 8 хорооны иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх.

1 ЗОРИЛТ 1 БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

Улс, хотын бодлого, зохицуулалтыг сайжруулж, уур амьсгалын эрсдэлд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх.

- Дасан зохицох хэрэгцээний судалгаа
- Эрсдэлийн үнэлгээ, бодлогын зөвлөмж
- NAP, NDC-д хотын асуудлыгтусгах хэлэлцүүлэг

2 ЗОРИЛТ 2 ЧАДАВХ, ОРОЛЦОО

Улс, хот, олон нийтийн түвшинд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бий болгох.

- Иргэдийн бүлэг, оршин суугчдын зөвлөл
- Гамшгийн сургалт, арга хэмжээ
- Иргэдийн оролцоо, бүлэг хамтын ажиллагаа

3 ЗОРИЛТ 3 ДЭД БҮТЭЦ

Зорилтот хороодод үерээс хамгаалах байгууламж барьж, эрсдэлийг бодитоор бууруулах.

- Инженер, гидрологийн судалгаа
- Суваг, далан, ус хуримтлуулах сан
- Ариун цэвэр, мод, зүлэгжүүлэлт

4 ЗОРИЛТ 4 МЭДЛЭГ, ТҮГЭЭЛТ

Үр дүнг тогтвортой болгож, бусад гэр хорооллолд давтах мэдлэгийн санг бүрдүүлэх.

- Мэдлэгийн бүтээгдэхүүн, товхимол
- Олон улсын туршлага
- Олон нийтэд түгээх

«Гэр хорооллыг зөвхөн хамгаалах биш, ирээдүйд тэсвэртэй болгох»

Аюулгүй иргэд **Ногоон дэд бүтэц** **Тэсвэртэй хот**



2026 ОНЫ 9-Р САРЫН БАЙДЛААР

Нэгдсэн үр дүн

21,528
оршин суугч үерээс хамгаалагдсан

5,361
өрхийн үерийн эрсдэл буурсан

220.5 га
суурьшлын бүс хамгаалалтад

2
байршил: Толгойт ба Гүнжийн булаг–Бэлх

325
үерт тэсвэртэй ариун цэврийн байгууламж

3,370
мод, бут иргэд тарьсан

4,000
өрхөд «Бэлэн бай» сургалт зөвлөгөө хүрсэн

16
дасан зохицох арга хэмжээ нийслэлийн төлөвлөгөөнд туссан

386,219
цахим хандалт, нийгмийн сүлжээнд

0 өрх 2025–2026 оны өвөл Толгойтод халиа дошинд өртсөнгүй. Өмнө нь жил бүр **140** хүртэлх өрх өртдөг байв.

ЗОРИЛТ 1 · БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

Уерийн эрсдэл бодлогын баримт бичигт орлоо








5
хороо, дүүргийн түвшний уерийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ

2
хот байгуулалтын бодлогод хийсэн үнэлгээ, зөвлөмж

16
дасан зохицох арга хэмжээ нийслэлийн 2024–2028 оны төлөвлөгөөнд

20+
уерийн арга хэмжээ СБД, СХД-ийн төлөвлөгөөнд

93
оролцогчтой үндэсний хэлэлцүүлэг, 70 нь эмэгтэй

4
бодлогын хэлэлцүүлэг, семинар NAP, NDC-ийн шинэчлэлд

НИЙСЛЭЛИЙН УУР АМЬСГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ · 2026–2035

Улаанбаатар хотын уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөгөө

Нийслэлийн Байгаль орчны газрын хүсэлтээр Уур амьсгалын өөрчлөлт, хөгжлийн академитай хамтран төслийг боловсруулж хүргүүлэв. Төлөвлөгөө нь уур амьсгалын эрсдэл, хүлэмжийн хийн ялгарлыг үнэлж, сааруулах, дасан зохицох тэргүүлэх арга хэмжээ, санхүүжилт, хяналтыг тодорхойлсон.

✓ **Төсөл хүргүүлсэн**
Нийслэлийн Байгаль орчны газарт

✓ **2026.09.09**
60 байгууллагатай хэлэлцүүлэг, саналыг тусгаж байна

3 **Батлуулах**
Хотын ажлын механизм, дараа нь НИТХ-аар

2 / 2 · Уур амьсгалын эрсдэлд нийцүүлсэн бодлого, төлөвлөгөөний эцсийн зорилтод хүрэв.

ҮНДЭСНИЙ БОДЛОГОД ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

2026 оны 2-р сард дууссан үнэлгээ төслийг маш ач холбогдолтой, уялдаатай хэмээн дүгнэж, хотын дасан зохицох асуудлыг **NDC 3.0** болон Дасан зохицох үндэсний төлөвлөгөөнд (**NAP**) тусгасныг онцолсон. Эрсдэлийн үнэлгээнд эмэгтэйчүүдийн оролцоо 50%-иас давсан.

ЗОРИЛТ 2 · ЧАДАВХ, ОРОЛЦОО

Иргэд эрсдэлээ бууруулагчид болов

Бүлгүүд гудамж, хэсгийнхээ эрсдэлийг өөрсдөө үнэлж, хамтын дасан зохицох төлөвлөгөө гаргадаг болсон. Суваг, далангийн цэвэрлэгээ, мод арчилгааг иргэд хариуцаж, барилгын ажлыг ч хянаж байна.





66
иргэдийн бүлэгт 614 өрх, 2,222 хүн нэгдсэн

90
«Бэлэн бай» сургагч багш, 78 нь эмэгтэй

4,000
өрхөд гамшгаас сэргийлэх зөвлөгөө хүрсэн

15,525
удаагийн оролцоо, 176 арга хэмжээнд

54%
оролцогчид эмэгтэйчүүд

58%
төслийн багийн эмэгтэйчүүдийн эзлэх хувь

ТӨСЛИЙН ДАРАА Ч ҮРГЭЛЖЛЭХ МЕХАНИЗМ

Онцгой байдлын ерөнхий газартай хамтран 2026 оны 6-р сард **68** хэсгийн ахлагчийг «Бэлэн бай» сургагч болгосноор мэдээлэл айл бүрд хүрч байна. «ЗХ» хурдасгуур хөтөлбөр иргэдийн байгууллагуудыг төсөл бичих, хөрөнгө босгох чинглэлээр чадавхжуулав.

ЗОРИЛТ 3 · ҮЕРЭЭС ХАМГААЛАХ ДЭД БҮТЭЦ

БАЙРШИЛ 1 · СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ · 4, 5, 26, 27-Р ХОРОО

Толгойт голын сав газар



12,092
оршин суугч хамгаалагдсан

3,002
өрх

60.6 га
суурьшлын бүс

Юу баригдсан бэ?

2,053 м
үерийн хамгаалалтын суваг, далан

54,363 м³
багтаамжтай 2 ус хуримтлуулах сан

3
явган хүний гүүр, иргэдийн саналаар

21,400 м²
далангийн налуу зүлэгжүүлэлт

15–30 мянган $
мөс цэвэрлэгээний жилийн зардал хэмнэгдэв

Жил бүрийн үер, халиа дошингоос хамгаалалт руу

2018 оноос хойш жил бүр үерт өртдөг байсан Толгойт голын эрэг одоо далан, суваг, усан сангаар хамгаалагдсан.

2025 оны 8-р сарын 23-ны УБ хотын их хэмжээний үер, аадар бороony үеэр айлуудыг хохиролгүй үлдэв.

2025-2026 оны өвөл цас их орсон ч үерийн хамгаалалтын систем **80%** орчим ачаалалтай ажиллаж, нэг ч айл халиа дошинд өртсөнгүй. Мөн үерийн байгууламжаас урагшаа өөр байршил болох 27-р хорооны орон сууцны хорооллын В1 давхар ус, мөсөд автахаа больж **1,672** өрхийн эд хөрөнгө хамгаалагдав.

Зураг төсөл: Үерийн хамгаалалтын байгууламжийн зураг төслийг Усны Эрчим ХХК боловсруулж батлуулсан.
Гүйцэтгэгчид: Тех Монтаж ХХК, Гранд Авгуш ХХК, Үржих Үр ХХК, Цэгээн Хайрханы Оршин Суугчид ТББ

Толгойт: мөсөөс ногоон далан хүртэл



Халиа дошин, шар ус айлуудын хашаа, гудамжаар урсдаг байв.



Суваг, далан ашиглалтад орж, ус тодорхой голдиролоор аюулгүй урсаж, далангийн дагуу ногоон зурвас бий болсон.

140 → 0 халиа дошинд өртдөг өрхийн тоо, 2025–2026 оны өвөл

Толгойт: хашаанаас мөс арилав

ӨМНӨ



Өвөл бүр халиа дошин айлуудыг тойрон хуримтлагдаж, байшин, хашаа, гудамж мөсөнд живдэг байв.

ОДОО



Ус, мөс одоо айлуудаас холуур, бэхэлгээтэй сувгаар урсаж, далангийн налуу бүхэлдээ ногоорч, өнгөрсөн өвөл нэг ч айл халиа дошинд автсангүй.

Зурагт: 26-р хорооны Засаг дарга Б.Батбаяр

3,002 өрх, 12,092 оршин суугч Толгойтод үерээс хамгаалагдсан

БАЙРШИЛ 2 · СҮХБААТАР ДҮҮРЭГ · 15, 16, 18, 20-Р ХОРОО

1. Гүнжийн булаг, Сэлх гол
2. Бэлх голын дагуу газар



9,436
оршин суугч хамгаалагдсан

2,359
өрх

159.9 га
суурьшлын бүс хамгаалагдсан

Юу баригдсан бэ?

4,771 м
үерийн суваг, далан (172,157 м³ багтаамж)

79,752 м³
ус тохируулах цөөрөм, 16-р хороо

775 м
чулуу, бетон бэхэлгээтэй далан, Гүнжийн булаг

260 м
иргэдийн санаачилгаар зарим айл өрхүүдийн орчмыг үер, хаоиа дошиноос хамгаалсан бичил суваг

3 явган хүний гүүр, 5 автомашины гарам
гэрэлтүүлэг, тохижилтын ажлууд

Хэмнэлттэй, ногоон шийдэл

Айлууд өвөл бүр мөсөн үерт машин, хашаа, замаа хучуулж, гэрээсээ гарч чадахгүй болдог байв.

Анхны зураг төсөл **21 сая $** байсныг ногоон, хэмнэлттэй шийдлээр **3.7 сая $**-т багтаав. Ойн газрын тохижуулсан эргийг хамгаалахын тулд сувгийн оронд ус тохируулах цөөрөм барихаар тохиролцов.

Нэмэлт үлдсэн ажил 2027 оны 7-р сар хүртэл үргэлжилнэ.

Гүйцэтгэгчид: Төрөлх Мөрөн ХХК, Хайдро Проект ХХК, Алтлаг Нар ХХК, Ойжид Дэвжих ТББ

Гүнжийн булаг: мөсөн үерээс аюулгүй гудамж



Халиа дошин айлуудыг тойрон хуримтлагдаж, гэрээсээ гарах аргагүй болгодог байв.



Далан баригдаж, айлуудыг мөсний хуримтлалаас хамгаалж байна.

775 м далан Гүнжийн булгийн айлуудыг халиа дошингоос хамгаална

Бэлх гол: айлуудыг хамгаалсан суваг



Мөсөн үерт машин, хашаа, зам хучигдаж, хөдөлгөөн зогсдог байв.



4.7 км суваг баригдаж, усыг айлуудаас холуур, тодорхой голдиролоор урсгаж байна.

2,359 өрх Сүхбаатар дүүрэгт үерээс хамгаалагдсан

ЗОРИЛТ 3 · АЮУЛГҮЙ ЗОРЧИХ ОРЧИН

Гүүр, гаргуур: аюулгүй зорчих орчин

Үерийн сувгийн барилгын ажилтай уялдуулан оршин суугчид болон хороодын Засаг захиргааны хүсэлтэд үндэслэн айл өрхийн орчмын жижиг ус зайлуулах шугам, хоолой, авто замын гаргуур, явган хүний гүүр, гэрэлтүүлгийн шон зэрэг аюулгүй зорчих нөхцөлийг мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоотойгоор бүрдүүлж байна.

7 явган хүний гүүр

5 автомашины том, жижиг гүүр, гаргуур

ӨМНӨ Мөсөн үер гудамж, гарц, гүүрийг хаадаг байв







ОДОО Ус гүүр, хоолойгоор дамжин аюулгүй урсаж байна







ЗОРИЛТ 3 · НОГООН ШИЙДЭЛ

Ногоон шийдэл, иргэдийн оролцоо




3,370 мод, бутыг иргэд далан, сувгийн дагуу тарьсан



25.8 мянган м²

газрыг мэргэжлийн байгууллага, багш аргазүйчтэй хамтран зүлэгжүүлэв





Ээлжлэн усалж, арчилгаа хийж байна



> *Ногоон шийдэл бетоноос хямд бөгөөд хөрсийг бэхжүүлж, урсгалыг сааруулдаг.*

ЗОРИЛТ 3 · ЭРҮҮЛ АХУЙ

Уерт тэсвэртэй ариун цэвэр





325
уерт тэсвэртэй байгууламж

499
өрх ашиглаж байна

1,990
иргэнд эрүүл орчин

744 тн
бохироос хөрсийг хамгаалав




Иргэд өөрсдөө суурилуулж байна



Хүн бүрт ээлтэй, уерт тэсвэртэй

Уерийн үед нүхэн жорлонгийн бохир ус, хөрсөөр дамжин тархаж, айлуудын эрүүл мэндэд эрсдэл учруулдаг байлаа. Шинэ байгууламжууд энэ эрсдэлийг бууруулж байна.

Хүн төвтэй загвар нь хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй бөгөөд айл өрхүүд өөрсдөө барилгад нь оролцсон.

Иргэдийн бүлгүүд өөрсдөө. Ариун цэврийн байгууламж суурилуулах ажлыг иргэдийн бүлгүүд сургалтад хамрагдаж чадавхжсаны дүнд өөрсдөө гүйцэтгэж байна. Ингэснээр зардал хэмнэгдэж, бүлгүүд дараа нь бусад айлд туслах ур чадвартай болж байна.

Төлөвлөсөн **400** байгууламжийн үлдсэнийг үргэлжлүүлэн барьж байна.

ЗОРИЛТ 4 · МЭДЛЭГ, ТҮГЭЭЛТ

Туршлагаа олон нийтэд түгээв

386,219
удаагийн хандалт нийгмийн сүлжээнд

93
нийтлэл 2025.07–2026.09 хооронд

12,090
like, 6,829 удаа хуваалцсан

50+
инженер «Хөвөн хот» олон улсын сургалтад

4
нийтлэл НҮБ-Хабитатын бүс нутгийн сайтад

1,500
товхимол иргэдэд тараасан

Олон улсын туршлага
ШУТИС-д Харбины ТИС-ийн эрдэмтэд «Спонж Сити», тогтвортой ус зайлуулах систем (SUDS), байгальд суурилсан шийдлийг 4 өдөр заав.

Дэлхийн гудамж төлөвлөлтийн гарын авлага
БОУАӨЯ-ны хүсэлтээр «Global Street Design Guide»-ийг монгол хэлнээ орчуулж, уур амьсгалд дасан зохицсон хот төлөвлөлтийн олон улсын туршлагыг нутагшуулав.

COP17 ба Гүйцэтгэх захирлын айлчлал
COP17-ийн үеэр НҮБ-Хабитатын Гүйцэтгэх захирал Анаклаудиа Россбах Толгойтод айлчилж, иргэдтэй уулзав. Үр дүнг Цэнхэр бүсэд танилцуулав.

Ном, товхимол
«Цэвдгийн өөрчлөлт бидний амьдралд» танин мэдэхүйн ном, «Иргэдийн түүх, туршлагууд» эмхэтгэлийг хэвлэн түгээв.

Нэгдсэн мэдлэгийн сан
Төслийн мэдээллийг нэгтгэсэн вэб платформын бүтцийг боловсруулав.

Хүүхэд, залуучуудад
Цэвдэг, үерийн эрсдэлийн танин мэдэхүйн контент, сурагчдын зургийн уралдаан зохион байгуулав.











АМЖИЛТЫН ТҮҮХ

11 гишүүнтэй бүлгээс хамтын хүч болтол





Г.Бөхболдын ахалдаг «Баянхайрхан» бүлэг 2019 онд Сонгинохайрхан дүүргийн 24-р хорооны 61-р гудамжинд ердөө 11 гишүүнтэй байгуулагджээ.

Дараа нь бүлгүүд нэгдэж, үерийн бүсийн оршин суугчдын амьдрах орчныг сайжруулах зорилготой «Цэгээн хайрханы оршин суугчид» ТББ-ыг байгуулав.

Тэд төслийн хүрээнд сайжруулсан жорлон барьж, айлуудын ариун цэврийн нөхцөлийг сайжруулав. Зүлэгжүүлэлт, явган хүний гүүр, гадаргын усны жижиг сувгийг ч багаараа бие даан барьж, чанартай хүлээлгэн өгсөн. Өнөөдөр тус ТББ Толгойт голын гүүр, ногоон байгууламжийн гүйцэтгэгчээр ажиллаж байна.

170

сайжруулсан жорлон барьсан

255

айлын ариун цэврийн нөхцөл сайжирсан

11 → ТББ

бүлгээс төрийн бус байгууллага болтлоо

2026 ОНЫ 8-Р САРЫН 25

НҮБ-Хабитатын Гүйцэтгэх захирал Анаклаудиа Россбах Толгойт голын талбарт ирж, үр дүнтэй танилцав. 26-р хорооны оршин суугч Д.Нэргүйбаатар далан, суваг, усан сан баригдсанаар айлуудын амьдрал хэрхэн сайжирсныг төлөөлөгчдөд ярьж өгчээ.

СУРГАМЖ, ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Юу сурав, цааш юу хийх вэ?



Сургамж

01 Уян хатан, шуурхай удирдлага
Гэнэтийн эрсдэлд хорооны удирдлагатай хамтран шуурхай шийдвэр гаргах нь айл өрхийг хохирлоос хамгаалж, иргэдийн итгэлийг бэхжүүлдэг.

02 Өвлийн хяналтыг төлөвлөх
Мөсний урсгал зураг төслийн таамаглалаас зөрж болох тул жил бүр өвлийн инженерийн хяналтыг төлөвлөж, төсөвлөх хэрэгтэй.

03 Зорилтот бүлгийг тооцох нь
Аливаа хийглсэн ажлууд, эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настны саналыг сонсох нь байгууламжийг хүн бүрт аюулгүй болгодог.

04 Бичил ус зайлуулалт
Үндсэн сувгийн орчны жижиг шуудуу, хоолой зэрэг бичил ус зайлуулалт зэрэг ажлууд нь системийн үр нөлөөг нэмэгдүүлдэг.

05 Дэд бүтцийн дэд ажлууд тохижилт
Цахилгаан, холбоо, гэрэлтүүлэг, ногоон байгууламж зэрэг нь иргэдтэй мэдээлэл солилцоо зөвшилцөлд суурилдаг .

06 Мэргэжилтэн ба иргэдийн хамтын ажиллагаа
Мэргэжлийн байгууллага газар дээр нь заах нь иргэдийн ур чадварыг хурдан бэхжүүлж, байгууламжаа өөрсдөө арчлах суурь болдог.

Сайн туршлага

Байгальд суурилсан шийдэл
Зүлэг, мод бүхий налуу хөрсийг бэхжүүлж, бетоноос хямд, байгальд ээлтэй хамгаалалт болдог. Бусад байршилд давтан хэрэгжүүлэх боломжтой.

Байгууллага хоорондын хамтын шийдэл
Төрийн байгууллагуудтай эрт мэдээлэл солилцох нь өмнөх хөрөнгө оруулалтыг хамгаалсан уян хатан шийдэл олоход тусалдаг.

Аюулгүй байдал
Анхааруулах самбар, хамгаалалтын хаалт зэрэг энгийн арга хэмжээ иргэд, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангадаг.

Тогтвортой байдал

Хүлээлгэн өгөх
Байгууламжийг дүүрэг, хорооны захиргаанд хүлээлгэн өгч, иргэдийн бүлгүүд өдөр тутмын арчилгааг хариуцна.

Техникийн хяналт
Геодези, усны барилга байгууламжийн газар техникийн хяналтад оролцож, үндэсний стандартад нийцүүлж байна.

Иргэдийн байгууллага
Иргэдийн байгууллагууд институтын хэлбэрт орж, засаглал сайжран, хөрөнгө босгох чадвартай болсноор цаашид бие даан ажиллах боломжтой.

Гамшгийн бэлэн байдал
Хэсгийн ахлагчаар дамжих «Бэлэн бай» сүлжээ төслийн дараа ч гамшгийн мэдээллийг айл бүрд хүргэнэ.

ЦААШИД · 2027.07.26

Үлдсэн ажлыг дуусгаж баталгаажуулах, мөсний байнгын хаалт барих, гомдлыг шийдвэрлэх, байгууламжуудыг баримтжуулан хүлээлгэн өгөх.



ХАМТДАА
ТЭСВЭРТЭЙ ГЭР ХОРООЛЛЫН ТӨЛӨӨ

Инженерийн шийдэл, иргэдийн оролцоо, ногоон шийдэл нэгдэж байж гэр хороолол аюулгүй, тэсвэртэй болно.

ADAPTATION FUND
UN HABITAT FOR A BETTER URBAN FUTURE
ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ

Хөгжлийн Шийдэл ТББ
Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Peace Tower, 703 тоот
info@dsmongolia.org · dsmongolia.org